



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/712

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 75 дугаар
цэцэрлэгийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,628,087.63 /хоёр сая зургаан зуун хорин найман мянга наян долоон төгрөг, жаран гурван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэг /Г.Танхил/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 232,818.30 /хоёр зуун гучин хоёр мянга найман зуун арван найман төгрөг, гучин мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 6 нэр төрлийн 2,395,269.33 /хоёр сая гурван зуун ерэн таван мянга хоёр зуун жаран есөн төгрөг, гучин гурван мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэг /Г.Танхил/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050001863

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 12 дугаар
сарын 27 өдрийн 05/12 тоот тушаалын хавсралт



Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн 75 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	ЭБХХХК-н шийдвэр
1	CD тоглуулагч	9	ш	1	96,433.33	96,433.33	96,433.33	-	Татах
2	Махны машин	40	ш	1	151,956.00	151,956.00	151,956.00	-	Татах
3	2-р хоолны тогоо	5	ш	1	556,850.00	556,850.00	556,850.00	-	Татах
4	Дижитал фото аппарат	9	ш	1	193,000.00	193,000.00	193,000.00	-	Татах
5	Зургийн аппарат	7	ш	1	197,230.00	197,230.00	197,230.00	-	Татах
6	Өсгөгч пульт	8	ш	1	1,199,800.00	1,199,800.00	1,199,800.00	-	Татах
Машин тоног төхөөрөмжийн дүн						2,395,269.33	2,395,269.33	-	
7	Сандал	18	ш	1	232,818.30	232,818.30	232,818.30	-	Устгах
Тавилга эд хогшлын дүн						232,818.30	232,818.30	-	-
Нийт данснаас хасагдах хөрөнгийн дүн						2,628,087.63	2,628,087.63	-	
Үүнээс: Худалдах хөрөнгийн дүн									
Устгах хөрөнгийн дүн						232,818.30	232,818.30	-	
Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн						2,395,269.33	2,395,269.33	-	
Худалдсанаас олох орлого									
НӨАУГ-т төвлөрүүлэх 30%									